



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: Gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Д.Дэмбэрэлсүрэн

Утас: 70523020

Цахим хаяг: Demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Бзб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.05.26 № 16/359

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ч.ТҮВШИНТӨР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,752.8	5,204.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	44,947.4	49,995.4
	Нийт хөрөнгийн дүн	48,700.2	55,200.1
	Нийт өр төлбөрийн дүн	22.9	567.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	48,677.3	54,632.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	48,700.2	55,200.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	25,435.2	30,857.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	20,418.4	25,439.3
	Үйл ажиллагааны үр дүн	5,016.7	5,418.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	274.5	297.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	4,742.3	5,120.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	22,278.2	21,168.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	21,520.3	19,612.8
	Үйл ажиллагааны ЦМГ	757.9	1,555.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(673.5)	(1,240.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	84.4	315.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	271.9	356.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	356.3	672.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,413.8	53,505.3
	Тайлант оны үр дүн	4,742.3	5,120.4
	Эцсийн үлдэгдэл	48,677.3	54,632.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	18,545.4
	Урсгал зардал	-	17,806.2
	Хөрөнгийн зардал	-	739.2
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	18,938.3
	Улсын төсвөөс санхүүжих	-	13,784.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	4,788.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	341.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		26.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		419.5

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайншанд сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, цомхон чадварлаг боловсон хүчинтэйгээр төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудын харилцан хамтын ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангаж ажиллаж, салбар салбартаа үйл ажиллагаагаар тэргүүлэн ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлж, бизнесийн таатай орчин бүрдүүлэх замаар бизнест шаардлагатай хатуу дэд бүтцийг хөгжүүлж, эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, бизнесийн хөгжлийг дэмжинэ.
- Эдийн засгийн салбаруудын чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн нөөцөд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэн дэмжиж хүн амын эрэлт, хэрэгцээг бүрэн дүүрэн хангана.
- Төр, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хүмүүнлэг, эрүүл, боловсролтой иргэдийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчноо хамгаалж, нөөц баялгийг зүй зохистой ашиглан байгалийн тэнцвэрийг хадгална.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 154 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 14 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 29 төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сангийн 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 12 байгууллагад дүгнэлт гаргаж, 15 байгууллага, 2 сан түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт 11, хязгаарлалттай дүгнэлт 1 өгсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 зөрчилд илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,078.39 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5,019.6 сая төгрөгийн 41 алдааг аудитын явцад залруулж, 51.3 сая төгрөгийн 26 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6.0 сая төгрөгийн 9 алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 32 зөвлөмжийг хүргүүлээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 154 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, тушаал шийдвэртэй холбоотой 134.5 сая төгрөгийн 26 захирамжийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7 сая төгрөгөөр

[illegible]

13	3-р сургууль	1	0.20	1	0.2	-	-	-	-	-	-	Зөрчилгүй
14	4-р сургууль	6	623.70	2	623.7	-	-	2	-	2	-	Зөрчилгүй
15	5-р сургууль	1	6.25	1	6.3	-	-	-	-	-	-	Зөрчилгүй
16	1-р цэцэрлэг	1	-	-	-	-	-	-	-	1	-	Түүвэр
17	2-р цэцэрлэг	2	0.39	-	-	-	-	1	0.4	1	-	Түүвэр
18	3-р цэцэрлэг	3	0.45	-	-	1	0.5	1	-	1	-	Түүвэр
19	4-р цэцэрлэг	3	15.49	1	15.5	-	-	1	-	1	-	Түүвэр
20	5-р цэцэрлэг	4	1.62	-	-	3	1.6	1	-	-	-	Түүвэр
21	6-р цэцэрлэг	2	0.67	1	0.7	-	-	-	-	1	-	Түүвэр
22	7-р цэцэрлэг	5	3.49	2	3.4	1	0.1	1	-	1	-	Зөрчилгүй
23	8-р цэцэрлэг	2	4.40	2	4.4	-	-	-	-	-	-	Түүвэр
24	9-р цэцэрлэг	8	8.57	4	6.0	-	-	3	2.5	1	-	Түүвэр
25	10-р цэцэрлэг	2	-	-	-	-	-	1	-	1	-	Түүвэр
26	11-р цэцэрлэг	6	2.23	-	-	1	2.0	2	0.1	3	0.1	Түүвэр
27	12-р цэцэрлэг	4	2.08	3	2.1	-	-	-	-	1	-	Түүвэр
28	13-р цэцэрлэг	3	50.74	1	50.7	-	-	2	-	-	-	Түүвэр
29	14-р цэцэрлэг	6	4.98	3	3.7	1	1.0	1	0.3	1	-	зөрчилгүй
30	ЗБСоёл, спорт	3	-	-	-	-	-	-	-	3	-	түүвэр
31	ОНХС	4	642.13	3	642.1	-	-	-	-	1	-	түүвэр
32	СХС	5	140.16	3	99.6	-	-	1	39.6	1	1.0	түүвэр
Нийт дүн		112	5,091.2	45	5,025.9	9	5.9	26	52.4	32	6.9	Зөрчил - 65.21 сая.төг